

## МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Уриа: “Эрдэнэт хүн, Шинэ Эрдэнэт хотын хөгжлийн төлөө”.

Миний бие Э.Баярхүү нь 2020 оны орон нутгийн ээлжит сонгуулийн санал хураалтаар иргэдээс ажил хийх итгэл хүлээж, сонгогдвол дараах чиг шугам, зорилтуудыг чанд сахин баримталж, эцэг эхээс өгсөн хүмүүжил, эзэмшсэн мэргэжил, ажилласан ажлын туршлага бүхнээ бүрэн дайчлан хувийн ашиг сонирхолгүй, нийтийн эрх ашгийг нэр түрүүнд тавьж хуулийн хүрээнд хэрэгжүүлж ажиллах болно. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн Хууль, түүнд нийцүүлэн гаргасан хуулиудыг улс төрийн болон төрийн албанд яв цав хэрэгжүүлэхэд онц анхаарч ажиллана,
2. Төрийн албаны ёс зүйг чанд сахиулах, шударга ёс тэгш байдлыг тогтооход идэвхтэй оролцож ажлаас үндэслэлгүй халагдсан иргэдийг ажилд нь эгүүлэн оруулах шүүхийн тогтоолыг хэрэгжүүлэхэд онц анхаарч ажиллана,
3. Улсын болон орон нутгийн, Эрдэнэт үйлдвэрээс хоттой байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд санхүүжүүлж байгаа хөрөнгийг зөв зохистой, нийтэд хүртээмжтэй захиран зарцуулахад хяналт тавина,
4. Эрдэнэт хот, Эрдэнэт хүний хөгжлийн төлөө ажиллаж байгаа иргэн, аж ахуй нэгж байгууллагыг дэмжих замаар ажлын байрыг нэмэгдүүлэх бодлого боловсруулж ажиллана,
5. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг иргэдэд нээлттэй, хөнгөн шуурхай, хүртээмжтэй, цахим болгоход санаачилгатай ажиллаж тэр дундаа худалдан авах ажиллагаа, газар эзэмшүүлэх, өмчлүүлэх, төрийн албанд шинээр орсон иргэний мэдээллийг тус тус хэвлэл мэдээллийн байгууллагууд, цахим орчноор нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулна,
6. Хотын ерөнхий төлөвлөгөөг холбогдох шинжлэх ухааны болон хот төлөвлөлтийн стандарт шаардлагад нийцүүлэн бүхэлд нь шинэчилж өмнөх нийтийн эрх ашгийг зөрчсөн, нэг талд давуу байдал бий болгосон, ногоон байгууламжийг устгасан төлөвлөгөөг цуцалж гэр хорооллын дахин төлөвлөлтөд онц анхаарч орон сууцжуулах хөтөлбөрийг бүрэн дэмжиж ажиллана,
7. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын байгууллага болон төрийн албан дахь хууль бус үйлдлийг таслан зогсооно,
8. Шинэ эрдэнэт хотын шинэ иргэдийг (0-18 насны хүүхэд) зөв төлөвшилттэй, эрүүл, боловсролтой болгоход хуульд хориглоогүй бүх арга хэмжээг хэрэгжүүлж, дэмжиж ажиллана,
9. Эрдэнэтийн иргэн, аж ахуй нэгжүүдийг хөгжих, ахиж дэвжих боломжийг бодлогоор дэмжиж үндэсний үйлдвэрлэгч болгох, цаашлаад дэлхийн зах зээлд гаргахад онц анхаарч ажиллана,
10. Орхон аймаг нь 2020 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр хотын статустай болж байгаатай холбогдуулан шинээр батлагдах хуулийн төслүүдэд саналаа хүргүүлж жуулчдын дамжин өнгөрөх зам бус бизнесийн болон аялал жуулчлал, үйлдвэрлэлийн, боловсролын төвшинд улсын жишиг хот болгоход онц анхаарч ажиллана,
11. Монгол Улсын Засгийн Газраас дэвшүүлсэн үйл ажиллагааны хөтөлбөр, Орхон аймгаас сонгогдсон Улсын Их Хурлын 3 гишүүний дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрт тусгагдсан ажлуудыг бүрэн дэмжиж ажиллана,

Орхон аймгийн иргэн Э.Баярхүүгийн “Мөрийн хөтөлбөр”-2020

12. Нийгэмд шударга ёс тогтоох чиглэлээр Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий Сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх Газрын дарга, Улсын Их Хурлын шударга гишүүдтэй нягт хамтран ажиллаж иргэдийн дуу хоолойг төрийн төвшинд хүргэж ажиллана,

13. Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан болон шинээр гаргах хуулиудыг орон нутагт хэрэгжүүлэхэд дагалдан гарах аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, журмуудад идэвх санаачилгатай мэргэжлийн төвшинд ажиллана,

14. Төрийн болон төрийн өмчийн, орон нутгийн өмчийн оролцоотой байгууллагуудын ажлын байрны дарамтыг арилгах, ажиллагчдыг тайван ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллана,

15. Архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг байгууллагуудын тоог хуулиар тогтоосон хэмжээнд хүргэх, нийтийн орон сууцны байруудад үйл ажиллагаа явуулдаг дэн буудлуудын үйл ажиллагааг иргэдийн оролцоотой зогсоох,

16. Орхон аймаг, Эрдэнэт хотын хүнсний хэрэгцээг хангах зорилгоор Жаргалант суманд мах махан бүтээгдэхүүн, хүнсний ногооны тариалалт, боловсруулалтыг дэмжсэн төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж ажиллах,

17. Эх орны болон Эрдэнэтийн ирээдүйн эздийг сурч боловсрох, чанартай боловсрол эзэмших боломжийг бүрдүүлэх, орчин нөхцөлийг сайжруулахад бүх боломжийг ашиглан идэвх санаачилгатай ажиллана,

18. Нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрхийн гишүүдийг чадваржуулах, мэргэжил олгох, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг асран хамгаалах, төлөвшүүлэх, эрүүлжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай нягт хамтран ажиллана,

19. Гэр хорооллын иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллах, амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад онц анхаарч ажиллана,

20. Төрийн байгууллагуудын дарга, удирдлагуудын зайлшгүй шаардлагатай, нийгэмд, нийтэд үр өгөөжтэйгээс бусад үр ашиггүй, төсвийн мөнгөөр тансагладаг, аялж зугаалдаг зардлуудыг бүгдийг нь хасна, таслан зогссон.

ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:

ИРГЭН  Э.БАЯРХҮҮ

